



НИЙСЛЭЛИЙН СОЁЛЫН ТӨВ ӨРГӨӨНИЙ ЗАХИРЛЫН ТУШААЛ

2020 оны 10 сарын 12 өдөр

Дугаар А/21

Улаанбаатар хот

Шагнах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дугаар заалт, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчдийн 2013 оны 153 дугаар тогтоол, байгууллагын дотоод журмын 8.4 дүгээр заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын Урлагийн Гавьяат Зүтгэлтэн Лхагваагийн Эрдэнэбулган нь Соёлын Төв Өргөө байгуулагдсаны нээлтийн тоглолтыг найруулж эхлүүлснээс хойш жил бүрийн төрийн наадмын хүндэтгэлийн болон нийслэлийн ойн баярын тоглолтууд, томоохон арга хэмжээнүүдийн найруулагч, зөвлөхөөр хамтран ажиллаж ирсэн манай "Эртний сайхан чуулга"-ын ахмад уран бүтээлчдийн нэг юм. Урлагийн Гавьяат Зүтгэлтэн Лхагваагийн Эрдэнэбулганы 80 насны тэмдэглэлт ойн ёслол, их урлагтай амьдралаа холбосны 60 жилийн ойн арга хэмжээг тохиолдуулан хүндэтгэл үзүүлж, 350000 төгрөг /гурван зуун тавин мянган төгрөг/-өөр шагнасугай.

2. Шагналын мөнгийг тэтгэмжийн зардлаас тооцож, олгохыг ахлах нягтлан бодогч /Ө.Цолмон/-д зөвшөөрсүгэй.

ЗАХИРАЛ



Б.Байгалмаа

Б.БАЙГАЛМАА